Ужиг ковидын үед илэрч буй шинжүүдтэй уламжлалт анагаах ухааны оношийг дүйцүүлэх боломж

С.Сээсрэгдорж[1], С.Ваанчигсүрэн[2], С.Доржбат[3]

[1,3]АШУҮИС, МАУОУС
[2]АШУҮИС, АУС
Цахим шуудан: seesregdorj@mnums.edu.mn, Утас: 99296858

Түлхүүр үг:

Ужиг ковид
Уламжлалт
Анагаах
Харьцуулалт

Товч утга:

Үндэслэл: Ковидын халдвар аваад эдгэсэн хүмүүст илэрч байгаа олон шинж тэмдгүүдийн цаад учир шалтгааныг олж тогтоох нь чухал байгаа бөгөөд эдгээрийг дүйлгэж оношлоод эмчлэх хамгийн том нотолгоо бүхий боломж бол олон зуунаар шалгарсан уламжлалт анагаах ухаан болж байгаа нь шинэлэг агуулгатайн зэрэгцээ уламжлалт анагаах ухааны их нөөцийг илрүүлэн ашиглах ач холбогдолтой байна. **Зорилго:** Шинэ корона вирусийн халдварын дараах ужиг үед илэрч байгаа шинжүүдийг уламжлалтын анагаах ухааны өвчний оноштой дүйцүүлэн эмчлэх боломжийг харьцуулан тодруулах хүрээнд ДЭМБ-н мэдээлэл, Сайт, Scophus-д бүртгэлтэй сэтгүүлүүд, “АУДУ” сурвалж түүний зарим тайлбаруудыг эх хэрэглэгдэхүүн болгож “Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга”-аар харьцуулан, “Магадлан жагсаах арга”-аар төрөлжүүлэн онцлогийг тодруулж “Нэгтгэн дүгнэх арга”- аар хураангуйлан үнэлж судалгааг хийж гүйцэтгэлээ. **Үр дүн:** Ужиг ковидын шинжийн талаар хийгдсэн судалгааны үр дүнгээс авч үзвэл олон шинжүүдийг илэрч байгааг тогтоосон хэдий ч Оксфордын Их Сургуулийн эрдэмтэд эрүүл мэндийн сүлжээ бүхий TriNetX цахим өгөгдлийг ашиглан ковид-19 халдвар авч эдгээд 90-180 хоног байгаа 270.000 гаруй хүнийг хамруулан судлаад 1. Сэтгэл түгших (сэтгэл гутралд орох)-15%, 2. Хэвийн бус амьсгалах-8% Шалтгаан тодорхойгүй хэвлийн өвдөлт-8%, 4. Цээж, хоолой өвдөх-6% Мартамхай болох-4%, 6. Ядарч сульдах-6%, 7. Толгой өвдөх-5%, 8. Булчин өвдөх-1.5% хамгийн их давтамжтай илэрч байна гэж үзсэнийг баримтлах боломжтой байна. Ковидын дараа хамгийн их давтамжтай илэрч байгаа эдгээр шинжүүдтэй уламжлалт анагаах ухааны Нуугдсан, Хуучирсан, Булингартсан архаг явцтай ерийн халуун өвчний эмгэг жам, өвчний хамрах, хүрээ, шинжүүд тохирч байна. Түүнчлэн дүйлгэн авч үзэж байгаа дээрх уламжлалт өвчнүүд нь ковидын хурц үеийн хөнгөн хэлбэртэй дүйлгэн эмчилж ирсэн уламжлалт “Эс боловсорсон халуун өвчнөөс үүссэн архаг өвчнүүд байгаа нь нотолгоо болж байна. Ужиг ковидтой дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт өвчнүүдийн эмчилгээний зарчим нь тодорхой, эмчилгээ нь өвөрмөц байгаагийн зэрэгцээ эм, заслын сонголт ихтэй төдийгүй ужиг ковидын үед илэрч байгаа бусад олон шинжүүдийг хам байдлаар эмчлэх өргөн боломжтой байна. **Дүгнэлт:** Ковидын дараа хамгийн давтамжтай илэрч байгаа эдгээр шинжүүдийг уламжлалт анагаах ухааны хий, бадганы гэмийн бэлгэ чанаруудаар болон язгуурын хий, бадганы үйл ажиллагааны алдагдалтай холбон тайлбарлах боломжтой байна.

Үндэслэл: Дэлхийн улс орнуудад ковидын шинэ хэв маяг (new normal)-т бэлтгэх, хэрхэн дасан зохицож хэвийн амьдралаар байх арга зүй, аргачлалыг боловсруулж хэрэглэж байна. Нөгөө талаар “Удаан ковид”-ыг хэрхэн яаж эмчлэх нь тулгамдсан асуудлын нэг болжээ. Энэ талаар Оксфордын Их Сургуулийн эрдэмтэд ковидын халдвар аваад эдгэсэн хүмүүст илэрч байгаа шинжийн талаар судлаад илэрч байгаа олон янзын шинж тэмдгүүдийн цаад учир шалтгааныг олж тогтоох хэрэгтэй. Ингэснээр халдварын дараах шинж тэмдгийн урт хугацааны үр дагавраас урьдчилан сэргийлэх болон үр дүнтэй эмчлэхэд чухал ач

холбогдолтой байгааталаар өгүүлжээ[1].

Ковидын халдварыг бүрэн таньж мэдээгүй өнөө цагт халдварын дараа илэрч байгаа шинжүүдтэй нь дүйлгэж оношлоод эмчлэх хамгийн том нотолгоо бүхий боломж бол олон зуунаар шалгарсан уламжлалт анагаах ухаан болж байгаа бөгөөд энэ нь шинэлэг агуулгатайн зэрэгцээ уламжлалт анагаах ухааны эм, засал, сэргээн засах, урьдчилан сэргийлэх нөөцийг илрүүлэн ашиглах ач холбогдолтой байна.

Зорилго: Шинэ корона вирусийн халдварын дараах ужиг үед илэрч байгаа шинжүүдийг уламжлалтын анагаах ухааны өвчний оноштой дүйцүүлэн эмчлэх боломжийг харьцуулан тодруулах.

Зорилт:

1. Ужиг ковидын үед илэрч байгаа шинжүүдийн талаар гарсан мэдээллүүдийг харьцуулж нэгтгэх
2. Ужиг ковидын үед хамгийн их давтамжтай илэрч байгаа шинжүүдийг уламжлалт оноштой харьцуулж дүйлгэх.
3. Ужиг ковидтой дүйлгэн авч үзсэн уламжлалт оношны эм заслын эмчилгээний онцлогийг тодруулах

Арга, аргачлал: ДЭМБ-н мэдээлэл, Сайт, Scophus-д бүртгэлтэй сэтгүүлүүд, “АУДҮ” сурвалж түүний зарим тайлбаруудыг эх хэрэглэгдэхүүн болгож “Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга”-аар харьцуулан, “Магадлан жагсаах арга”-аар төрөлжүүлэн онцлогийг тодруулж “Нэгтгэн дүгнэх арга”- аар хураангуйлан үнэлж судалгааг хийж гүйцэтгэв.

Үр дүн: Удаан ковидын үед илэрч байгаа шинжүүдийн талаар хийсэн судалгааны тоймыг нэгтгэж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Эмнэлгээс гарснаас хойш 60 хоногийн дараа өвчтөнүүдийн 21% -д цээжний өвдөлт илэрч байсан. Жар хоног хяналтад байсан өвчтөнүүдийн 9% -д зүрх дэлсэх шинж байнга илэрч байсан тухай өгүүлжээ.[2-3]

Англид хийсэн судалгааны хамтарсан багийн үр дүнгээр ковид-19 халдвараар өвдсөний дараа үйлчлүүлэгчдэд 47%-д ядрах, 32%-д амьсгал давчдах, 25%-д булчингийн өвдөлт, 20%-д үе мөчөөр өвдөх, 18%-д толгой өвдөх, ханиалгах зовуурь 18%-д, цээжээр өвдөх хамж шинж 15%-д, 6-14%-д амт, үнэрийн мэдрэмж буурах шинжүүд хамгийн урт үргэлжилж байсныг мэдээлжээ.[4]

Мөн Английн Hull University Teaching эмнэлгээс гарсан нийт 387 эмчлүүлэгчдийг дагаж судлахад ковид-19 халдварын дараа нийт хүмүүсийн 60%-д нь амьсгаадах, 51%-д булчин өвдөх, сэтгэл түгших хам шинж 57.8%-д, ядаргаа 39.6%-д, нойргүйдэл 35.1%-д илэрч байсан бол үе мөчөөр өвдөх, цээжээр хатгуулах, тууралт гарах болон ханиалгах зовуурь дагалдах байдлаар илэрч байсныг тогтоожээ.[5]

Түүнчлэн БНХАУ-ын Ухань хотын нэгдсэн эмнэлэгт эмчлүүлж гарсан нийт 1733 хүнд Когорт судалгааны аргаар 186 хоног дагаж судлахад хамрагдсан нийт хүмүүсийн 63% нь булчин суларч, сул дорой болох шинж, 26% нойргүйдэлд орсон, 23% нь ямар нэг сэтгэлийн түгшүүртэй байдалтай байсан ба нийт үйлчлүүлэгдэгчдийн 50%-д цээжний СТ хийхэд уушгины хэвийн бус зураглал илэрч байсныг тогтоожээ.[6]

Удаан ковидын шинжийн талаар Оксфордын Их Сургуулийн эрдэмтэд эрүүл мэндийн сүлжээ бүхий TriNetX цахим өгөгдлийг ашиглан ковид-19 халдвар авч эдгээд 90-180 хонож байгаа 270.000 гаруй хүнийг хамруулан судлаад ковидын дараа үндсэн найман шинж тэмдэг хамгийн их давтамжтай илэрч байгааг тогтоосон томоохон судалгаа хийжээ. Үүнд: 1.Сэтгэл түгших/сэтгэл гутралд орох/-15%, 2. Хэвийн бус амьсгалах-8%, 3.Шалтгаан тодорхойгүй хэвлийн өвдөлт-8%, 4. Цээж, хоолой өвдөх-6%, 5. Мартамхай болох-4%, 6. Ядарч сульдах-6%, 7. Толгой өвдөх-5%, 8. Булчин өвдөх-1.5% шинжүүд нь нийт хамрагдсан хүмүүст 53.5%-ийн давтамжтай илэрсэн байдаг[1]. Оксфордын Их Сургууль, Эрүүл Мэндийн Судалгааны Үндэсний Хүрээлэн (NIHR) Оксфордын Эрүүл мэндийн био анагаахын судалгааны төв (BRC)-тэй хамтран хийсэн энэ судалгаагаар тогтоосон шинжүүдэд бусад судалгааны үр дүнгээр илрүүлсэн шинжүүдийн агуулга бүрэн хамрагджээ гэж үзэхээр байна.

Судалгааны үр дүнгээр тогтоогдоод байгаа хамгийн их давтамжтай илэрч байгаа шинжүүдтэй уламжлалт анагаах ухааны халдварт бус Нуугдсан, Хуучирсан, Булингартсан архаг явцтай ерийн халуун өвчний шинжүүд дүйж байна. Тухайлбал: Нуугдсан халууны өвчний үед хамгийн их давтамжтай илэрдэг “Сэтгэл их зовох, үе үе хөлрөх, биед хүнд, шөнө нойр бага өдөр нойр хүрэх, багахан хүч гаргаад амархан ядрах”[7], Хуучирсан халуунд хамгийн их давтамжтай илэрдэг “Хөдөлбөл уушги, зүрх дэлсэж, цээжээр халуун оргих, бие хүнд, тамир өчүүхэн, хөлс их гарах”[7], Булингартсан халууны өвчний үед хамгийн их давтамжтай илэрдэг “Хөдөлбөл амьсгал давхцах, уушги, зүрх дэлсэх, тамир өчүүхэн, амархан хөлрөх, цээжээр өчүүхэн хатгуулах”[7] зэрэг ерөнхий шүтэн барилдлагын шинжүүд тохирч байна. Ерөнхий шүтэн барилдлагад хамаарч байгаа шинжүүд нь нуугдсан халуун өвчний үед тавигдаж болох 6, Хуучирсан халуун өвчний үед тавигдаж болох 8, Булингартсан халуун өвчний үед тавигдаж болох 30 эмнэл зүйн оношны ангиллуудын тохиолдол бүгдэд **илрэх** ерөнхий шинжүүд болж байна.

Түүнчлэн дүйлгэн авч үзэж байгаа эдгээр уламжлалт оношны эмнэл зүйн явц удаан ковидын эмнэл зүйн явцтай дүйж байгаа төдийгүй дээрх дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт өвчнүүд нь ковидын хурц үеийн хөнгөн хэлбэртэй дүйлгэн эмчилж ирсэн уламжлалт “Эс боловсорсон халуун өвчнөөс үүссэн халуун өвчний ахуй үесийн ангилад ордог архаг өвчнүүд байгаа нь нотолгоо болж байна[8].

Дээрх дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт оношны эмчилгээний зарчмууд тодорхой байгаагийн зэрэгцээ зарчим тус бүрээр эм, засал, идээ ундаа, явдал мөрийн ерөндгүүдийг хэрэглэх бүрэн боломжтой байна. Дүйлгэн авч үзэж байгаа Нуугдсан халуун өвчний эмчилгээний зарчмыг 1. Эхлээд их хулгайчийг нүхэнд оруулах 2. Өрхийг татаж утааг гаргах 3. Сүүлд

нь халуун нурам руу ус цацах зарчмаар эмчилнэ[7] гэж заажээ. Үүнийг бага зэрэг эдүгээчилбэл эхлээд бадган, хийн бүрхүүлийг хуулж галыг ил болгоод түүнийгээ дарах эмчилгээний төлөвлөгөө бөгөөд зарчим бүрд тохирх шатлал тус бүрийн эм, засал, идээ ундаа явдал мөрийн эмчилгээ нь өөр өөр байна.

Булингартсан халууныг эмчлэхдээ 1. Нойтон элсийг хатаах мэт 2. Усыг сувагт горхилон татах мэт 3. Зөрөлдөөнийг эвлүүлэх[7] мэтээр засахыг заасныг эдүгээчлэн авч үзвэл өвчний шалтгаан болох шар усыг хатаахын хамт бие мах бодид үүсэх хаванг хөөж, үндсэн 7 тамирын боловсролтыг дэмжиж тэнцвэржүүлэх эмчилгээний зарчим бөгөөд тус бүрд нь хийх эмчилгээ мөн өөр өөр байна.

Хуучирсан халууныг эмчлэхдээ 1.Эхлээд хөшсөнийг чийгээр дэвтээх 2.Халууныг усаар шавших 3. Сүүлд нь хорын үндсийг угаас гаргаж арилгах зарчмаар эмчлэхийг заасан байдаг[7]. Үүнийг бага зэрэг эдүгээчилбэл эхлээд тархаж сарнисан өвчний гэмийг хураагаад түүнийгээ дараад сүүлд нь өвчнийг урхгийг хөөж биеэс зайлуулах зарчим бөгөөд мөн гурван шатлалд тохирох эмчилгээ нь өөр байдаг.

Дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт оношны эмчилгээний зарчмууд 1. Үг хэллэг өвөрмөц зүйрлэлтэй өвчний мөн чанарын анагаах гүнзгий агуулгатай байна. 2. Дүйлгэн авч үзэж байгаа өвчнүүдийг эмчилгээний зарчмаас үзэхэд өвчнийг олон үе шаттай эмчилж анагаах тухай заасан байна. 3.Ужиг ковидтой дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт оношны эмчилгээний зарчим хийгээд эмчилгээ нь бүрхүүл хуулах, хураах зэрэг тодорхой шатлалд тохирох тактикаар явагдаж байгааг уламжлалт анагаах ухааны онол арга зүйгээр авч үзвэл өвчнийг голомтлог байдалд оруулж анагааж байгаараа өвөрмөц байна.

Түүнчлэн Ковид-19-ийн үеийн болон дараах сийвэнгийн ферритиний ихсэлт, гол хүндрэл болоод байгаа судасны бүлэнг эдгээр дүйлгэн авч үзэж байгаа өвчнүүдийн хүрээнд эмчлэх боломжтой байгаа төдийгүй уламжлалт “Хар судасны цусан бэтэг” оноштой дүйлгэн хануур эмчилгээ хийсний дараа сийвэнгийн ферритин буурч уушгины рентген зурагт эерэг үр дүн гарч байгаа нь муу цусны гэмээс цусны урсгалын хурд удааширч цус зогсонгижсоноос эд эсийн тэжээл хомсдож ужиг үрэвсэлт өөрчлөлт үүсэж байсан нь эргэн сэргэж бие мах бод тэгширч байгаа үр дүн илэрсэн байдаг[9].

Хэлцэмж: Ковидын дараа илэрч байгаа эдгээр шинжүүд уламжлалт анагаах ухааны хий, бадганы гэмийн бэлгэ чанаруудаар дамжин илэрч байна. Тухайлбал хийн хөнгөн бэлгэ чанарын тайван биш, сэтгэлийн хөдөлгөөн их, уймраа болох, нойр муудах шинжүүд, сэрүүн бэлгэ чанарын бие илчгүй болж дааруч жихүүцэх, нарийн бэлгэ чанарын бүх бие яс үеэр шархирч өвдөх, бадайрах, янгинах, зүүд ихсэх, хөлбөрөнгө бэлгэ чанарын бүх бие яс үеэр шархирч өвдөх, бадайрах, янгинах, баярлах гомдох нь амархан болж олон ааштай болох шинжүүд хамгийн олон давтамжтай илэрч байна[10]. Бадганы тослог бэлгэ чанарын мартамхай болох сэтгэн бодох чадвар буурах, бадганы хүнд бэлгэ чанарын бие хүндрэх, залхуу хүрэх, хэвтмээр санагдах, мохдог бэлгэ чанарын мэдрэмж муудах, идэвхгүй болох, бэрхшээж зүрх алдах, хөдөлгөөн удаашрах, батлаг бэлгэ чанарын мэдрэмж муудаж хариу урвал багасах шинжүүд мөн илэрч байна[10].

Эдгээрийг өвчний гэмийн язгууртай холбож үзвэл амь баригч хий хямралдсаны сэтгэл тогтворгүй болох, мэдрэхүйн эрхтний үйл ажиллагаа муудах, амьсгал саадтай болох, дээш гүйгч хий хямралдсаны өвчүүний ард эвгүй оргих, түгээмэл гүйгч хий хямралдсаны зүрхээр өвдөх, цочромтгой болох, хангагч бадганы толгой дүйрч өвдөх, амсуулагч бадганы амтны мэдрэмж буурах шүтүүлэгч бадганы бөөлжис цутгах, хоолонд дургүй болох зэрэг шинжүүд илүү тод илэрчээ[10]. Эдгээр илэрч байгаа шинжүүдийг дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт оношны ялгавартай ангилалтай хамааруулан авч үзвэл нуугдсан халууны үед зүрх, бөөр, ходоодны өвчнүүд, хуучирсан халууны үед бүлх, шөрмөс, яс, үе, судасны хамааралтай шинжүүд булингартсан халууны үед зүрх судас, хаван, харшил зэрэг олон эрхтэн системийг хамарсан шинжүүд илүүтэй илэрч байгаатай холбон ялгавартай оношилж эмчлэх боломж өргөн байна.

Судлаачдын тогтоосон ужиг ковидын үед илэрч байгаа шинжүүд нь хий, бадганы гэмийн бэлгэ чанар, язгуурын хий, бадганы махбодтой холбоотой тайлбарлагдаж байгаа нь дүйлгэн авч авч үзэж байгаа уламжлалт оноштой харьцуулан авч үзвэл нуугдсан халуун өвчний шалтгаан нь бадган, хий байдаг, хуучирсан халууны шалтгаанд заавал хий оролцож тухайн оношны ерөнхий ангиллыг хийтэй хуучирсан, хийгүй дангаараа хуучирсан, булингартсан халуунд шар ус шалтгаан болдог хэдий ч мөн ерөнхийд нь халуунаар булингартсан, хүйтнээр булингартсан гэж ангилж үздэгтэй шууд хамаарал бүхий нотолгоо болж байна. Эдгээр дүйлгэн авч үзэж байгаа эмчилгээний зарчимтай холбон авч үзвэл эмчилгээг олон үе шаттай хийх хэрэгтэй байгаагийн зэрэгцээ бүрхүүл хуулах, хураах аргуудыг хэрэглэж өвчнийг голомтлог байдалд оруулж эмчилж байгаа нь бусдаас ялгарах онцлог бүхий өвөрмөц байна. Түүнчлэн халуун нурам руу руу ус цацах, хорын үндсийг угаас гаргах, зөрөлдөөнийг эвлүүлэх зарчмуудаар өвчний үндсийг таслах шалтгааны эсрэг эмчилгээ болж байгаа бөгөөд уламжлалт анагаах ухааны онол ёсоор авч үзвэл нэг өвчний эмчилгээ 28 хоног үргэлжлэхээр байна.

Ужиг ковидтой дүйлгэн авч үзэж байгаа эдгээр өвчнүүдийн эмчилгээний зарчим нь тодорхой эм, заслын сонголт ихтэй байгаа төдийгүй ужиг ковидын үед илэрч байгаа бусад олон шинжүүдийг хам байдлаар эмчлэх боломж өргөн байна. Нөгөө талаар ковидын цочмог халдварын хүндрэлийн зэргээс үл хамааран 5 хүн тутмын 1 нь 5 долоо хоног ба түүнээс дээш хугацаанд шинж тэмдэг илэрдэг бол 10 хүн тутмын 1 нь 12 долоо хоног ба түүнээс дээш хугацаанд шинж тэмдэгтэй байж болно.[11] гэсэн судалгааны үр дүнтэй дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт өвчнүүдийн эмгэг жамын явц, үе, шат, эмчилгээний шатлалтай холбон авч үзвэл ужиг ковид илүү удаан явцтай байх магадлал байгааг анхаарах шаардлага байна.

Дүгнэлт:

1. Ужиг ковидын үед илэрч байгаа шинжүүдийн талаар хийгдсэн судалгаануудын үр дүнг нэгтгэж үзвэл Оксфордын Их Сургууль, Эрүүл Мэндийн Судалгааны Үндэсний Хүрээлэн (NIHR) Оксфордын Эрүүл мэндийн био анагаахын судалгааны төв (BRC)-тэй хамтран хийсэн судалгааны үр дүнг баримтлах боломжтой байна.
2. Ужиг ковидын үед илэрч байгаа хамгийн их давтамжтай нь тогтоогдож байгаа шинжүүдтэй уламжлалт Нуугдсан, Хуучирсан, Булингартсан архаг явцтай ерийн халуун өвчний эмгэг жам, өвчний хамрах, хүрээ, шинжүүд тохирч байна.
3. Ужиг ковидтой дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт өвчнүүдийн эмчилгээний зарчим нь тодорхой, эмчилгээ нь өвөрмөц байгаагийн зэрэгцээ эм, заслын сонголт ихтэй төдийгүй ужиг ковидын үед илэрч байгаа бусад олон шинжүүдийг хам байдлаар эмчлэх боломж өргөн байна.

Ном зүй:

1. *https://www.ox.ac.uk/news/2021-09-29-over-third-covid-19-patients-diagnosed-least-one-long-covid-symptom*
1. *Carfì A, Bernabei R, Landi F, Gemelli Against COVID-19 Post-Acute Care Study Group. Persistent Symptoms in Patients After Acute COVID-19.JAMA. 2020 Aug 11; 324(6):603-605.*
2. *Satish R. Raj, Amy C. Arnold, AlexandruBarboi, Victoria E. Claydon, Jacqueline K. Limberg, Vera-Ellen M. Lucci, Mohammed Numan, Amanda Peltier, Howard Snapper, Steven Vernino on behalf of the American Autonomic Society. Long-COVID postural tachycardia syndrome: an American Autonomic Society statement. Clinical Autonomic Research (2021) 31:365–368*
3. *Harry Crook, Sanara Raza, Joseph Nowell, Megan Young, Paul Edison. Long covid-mechanisms, risk factors, and management. BMJ. 2021 Aug 3;374:n1944.*
4. *Dominic L. Sykes, Luke Holdsworth, Nadia Jawad, PumaliGunasekera, Alyn H. Morice, Michael G. Crooks. Post-COVID-19 Symptom Burden: What is Long-COVID and HowShould We Manage It?.Lung; Springer, 27 January 2021, Vol. 199, p113-119*
5. *Huang C, et al. 6-month consequences of COVID-19 inpatients discharged from hospital: a cohort study. Lancet.2021;397:220–32.*
6. *АУДУ. Манагжүд. 18-20-р бүлэг.*
7. *С.Сээсрэгдорж "Шинэ корона вирусийн халдварын үед илрэх шинжүүдийг уламжлалт анагаах ухааны сурвалж, зарим тайлбаруудын халдварт хижиг өвчний шинжүүдтэй харьцуулсан шинжлэл". Эрүүл мэндийн шинжлэх ухааны сэтгүүл 2020 он х. 154-159*
8. *Э.Жаргалхүү, Ж.Итгэлбаяр, Т.Лхамжав, Х.Пүрэвдулам, Ч.Батнайрамдал, С. Сээсрэгдорж Ковид-19 халдварын дараах сийвэнгийн ферритин ихсэлтийн үед хануур эмчилгээ хийсэн тохиолдол. Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ой. Уламжлалт анагаах ухааны салбар хуралдаан. УБ. 2021.12.17. Илтгэлийн хураангуй. Хуудас 80.*
9. *Сүрэнжид Сээсрэгдорж, Далх Цэрэндагва "Монгол анагаах ухааны өвчнийг шинжилж нотлохуйн нэгдмэл толь" УБ. 2021. Хуудас 82, 83, 85.*
11. *ONS. The Prevalence of Long COVID Symptoms and COVID-19 Complications. See https://www.ons.gov.uk/news/statementsandletters/theprevalenceoflongcovidsymptomsandcovid-19complications (last checked 26 January 2021).*

Comparative analysis between the Long Covid symptoms and the diagnosis of traditional medicine

Seesregdorj S[1], Vaanchigsuren V[2], [3] Dorjbat S[3]

[1,3]АШУҮИС, МАУОУС
[2]АШУҮИС, АУС
E-mail: Seesregdorj@mnums.edu.mn, Tel: 99296858

Background: Some people who have been recovered from COVID-19 but are still experiencing some symptoms, known as post-Covid condition. It is important to identify the causes of symptoms in post Covid. The greatest evidence-based opportunity to diagnose and treat post-COVID condition is traditional medicine, which has been around for centuries, and it is important to discover and use the huge resources of traditional medicine in addition to its innovative content.
Aim: To compare the Long Covid symptoms with the diagnosis of traditional medicine for the possibility of treating
Materials and Methods: Source materials were collected from WHO information, Scopus listed journals as well as commentaries of the "four medical tantras" and its major explanation sources. All collected data were analyzed by comparing and contrasting sourced method, verification method, and summarizing method
Results: According to the results of a study on the post-COVID condition, many symptoms were experienced but new study from the University of Oxford and the National Institute for Health Research (NIHR) Oxford Health Biomedical Research Centre (BRC) investigated long-COVID in over 270,000 people recovering from COVID-19 infection, using data from the US-based TriNetX electronic health record network. It is can be followed that the study reported common long-COVID symptoms, occurring 90-180 days after COVID-19 was diagnosed, comprise: 1. Abnormal breathing–8%, 2. Abdominal symptoms–8%, 3. Anxiety/depression–15%, 4. Chest/throat pain–6%, 5.Cognitive problems ('brain fog')–4%, 6. Fatigue–6%, 7. Headache–5%, 8. Myalgia (muscle pain)–1.5%. It is possible can be followed. "Method of comparison by text studies and source study", clarifying their diversified features of "Method of Inquiry lists" and "Method of integrated conclusion" for brief comparative study. These symptoms, which occur most frequently post Covid condition, are consistent with the latent fever, chronic fever, turbid fever. In addition, as for the above-mentioned traditional diseases, it is may proof that chronic diseases caused by unripened fever, which is treated with a mild form of acute Covid-19. The principles of treatment of traditional diseases, which are considered in conjunction with long Covid symptoms, are clear, the treatment is unique as well as there is a wide choice of prescriptions and treatments. Furthermore, many other symptoms of long Covid symptoms can be treated in combination.
Conclusion: These symptoms, which occur most frequently post Covid condition, may can be explained by the qualities of wind and phlegm, as well as in connection with the loss of root wind and phlegm functions.

Keywords: Long Covid, traditional, medicine, comparison